



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 566

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, З дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Архангай аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаанд сэргээн засварлах боломжгүй болсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 46,915,140.00 /дөчин зургаан сая есөн зуун арван таван мянга нэг зуун дөчин/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан З ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Архангай аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Д.Тунгалагт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Акталсан үндсэн хөрөнгийг сургалтын дадлагын хичээлд ашиглахаар байгууллагадаа үлдээж, эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дугээр сарын 03-ны өдрийн
566 дугаар тогтоолын хавсралт



Архангай аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, Хуриатлагдсан элэгдэл (төгрөг)
1	Автобус Хьюндай, 52-44 APX арал № KM9947MJD4KB1W001	2004/ 2011	26,915,140.00
2	Верна аксент, 12-58 APX, арал № KMHCG41GP2U332624	2002/ 2011	9,400,000.00
3	Верна аксент, 15-55 APX арал № KMHCG41FP1U276054	2001/ 2011	10,600,000.00
	Нийт дүн		46,915,140.00 <i>/дөчин зургаан сая есөн зуун арван таван мянга нэг зуун дөчин/</i>